

УЛААНБААТАР ХОТ

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК
/хаалттай/

"Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын
2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн
99 дугаартай албан бичгийн 1 дүгээр хавсралт
8194062 Л.ХНТ9663

**"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-ЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2025 оны 02 дугаар улирлын байдлаар/**

2025 оны 06 дугаар сарын 24

Багануур дүүрэг

Д/д	Өргөдөл, гомдлын агуулга	Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэх шатандаа байгаа		Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо					Иргэнд хариу хүргүүлсэн хэлбэр			Өргөдлийн төрөл				
			Шийдвэрлэх хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	1-10 хоногт	11-20 хоногт	21-30 хоногт	Хугацаа сунгасан	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тоо	Албан бичгээр	Утсаар	Биечлэн уулзах	Талархал	Санал	Хүсэлт	Гомдол	Мэдэгдэл
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1	Ажил хүссэн	10			10							+			+		
2	Дэмжлэг туслалцаа хүссэн																
3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой																
4	Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гаргасан өргөдөл	5			5							+			+		
5	Иргэдээс байгууллагын ажилтан, албан хаагчидтай холбоотой гаргасан өргөдөл																
6	Бусад																
	Нийт	15			15							15			15		

Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал

№	Ангилал	Тоо	Шалтгаан, тайлбар
0	1	2	15
1	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	1	Ажлаас чөлөөлөгдөх болон ажигд орох хүсэлт гаргасан иргэдийн өргөдлийг хүсэлтийн дагуу шийдвэрлэв
2	Боломжгүй тухай хариу өгсөн	-	-
3	Бусад	-	-

ХЯНАСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БЯМБАЦЭЦЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГАДААД ХАРИЛЦАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН *М. Мөнхдулам* М.МӨНХДУЛАМ

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК-ийн
2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн
99 дугаартай албан бичгийн 2 дугаар хэвсрэлт

2725050005
8184062 ХНТ9663

**"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ХК-д ИРГЭД,
АЛБАН ХААГЧДААС ИРҮҮЛСЭН ӨРГӨДЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2025 ОНЫ 02 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН**

2025 оны 06 дугаар сарын 24

Багануур дүүрэг

1.Манай байгууллагад 2025 оны 01 дүгээр улиралд 5 албан хаагч ажлаас чөлөөлөгдөх, 8 иргэн ажилд орох хүсэлт гаргасан. 2025 оны 02 дугаар улиралд 2 албан хаагч үүрэгт ажлаас чөлөөлөгдөх, 3 иргэн ажилд орох хүсэлт гаргаж, өргөдөл ирүүлсэн нь өмнөх оны тухайн үеийнхээс тооны хувьд илүү байна. Өргөдлийг өдөр өдөрт нь албан хаагчид болон иргэдийн хүсэлтийн дагуу, "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн даргын тушаалаар шийдвэрлэж, 5 албан хаагчийг үүрэгт ажлаас чөлөөлж, 10 иргэнийг ажилд авсан.

Тайлант хугацаанд иргэд, албан хаагчаас ирүүлсэн 15 өргөдлийг ERP системийн Өргөдөл, гомдол дэд хэсэгт бүртгэж, өргөдөл хяналтын картыг хөтөлж, өргөдөл болон өргөдөл хяналтын картаар хадгаламжийн нэгж үүсгэн архивлахад бэлтгэв.

Өргөдлийг хамгийн боломжит богино хугацаанд шийдвэрлэхийг зорьж байгаа ба ажлын 1 өдрийн дотор шийдвэрлэж байна.

2.Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.

3.Бүтээлч санал санаачлагын шинжтэй хүсэлт илэрхийлж, мэдээлэл хүссэн иргэдтэй байгууллагын удирдлага биечлэн уулзаж, Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэл, зөвлөгөө, чиглэл өгч ажилладаг. Энэ уулзалтын бүртгэлийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр албан бичгээр хүргүүлдэг. 2025 оны 02 дугаар улирлын байдлаар байгууллагын удирдлага нийт 6 иргэнтэй уулзсан байна.

3.1.Иргэд, аж ахуйн нэгжээс гаргасан бүтээлч санал санаачлагын хүсэлтийг Паркийн үйл ажиллагаатай уялдуулан нааштайгаар шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах зорилгыг хэрэгжүүлж ажилладаг. Тухайлбал, Багануур дүүрэгт Махны үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа Мах маркет ХК болон Мод боловсруулах төсөл хэрэгжүүлэх Натур Ларикс ХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулав.

4.Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг Компанийн цахим хуудасны ил тод байдал хэсэгт улирал бүр нээлттэй байршуулан ажиллаж байна.

5.Иргэдээс манай байгууллагын ажилтан, албан хаагчдын ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол байхгүй.

ХЯНАСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГАДААД ХАРИЛЦАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Б.БЯМБАЦЭЦЭГ

М.МӨНХДУЛАМ